



ЗАХ ЗЭЭЛИЙН ТОЙМ

04.13 - 04.17



ОЛОН УЛСЫН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

АНУ: Коронавирусын тархалт удааширч байгаатай холбоотой хөл хориог удахгүй цуцлана гэсэн хүлээлт үүссэн ч эдийн засгийн голлох үзүүлэлтүүд уналттай байгаа нь энэ долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийн индексүүд холимог үзүүлэлттэй байхад нөлөөллөө.

S&P500 индексийн сагсанд багтах Microsoft, Apple зэрэг тэргүүлэгч компаниудын хувьцааны ханш өсөлттэй байсантай холбоотой технологийн салбар хамгийн их өсөлттэй байлаа. Amazon компанийн хувьцааны ханш өсөлттэй байснаас үүдэн өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний салбар өсөлттэй мөн эм зүйн компаниудын хувьцааны ханш өсөлттэй байснаас эрүүл мэндийн салбар өсөлттэй байлаа.

АНУ-д вирусн тархалт хамгийн их байгаа бүс нутгуудад халдвар авагсдын тоо буурах хандлагатай болсноор Мягмар гарагт хөрөнгө оруулагчдын зах зээлд итгэх итгэл нэмэгдсэн байна. Түүнчлэн бүс нутгуудад эдийн засгийг сэргээх хөтөлбөрүүдийг гаргаж, зохион байгуулах хороодыг байгуулж эхлээд байгаа юм.

Европ: Энэ долоо хоногт Европын хөрөнгийн зах зээлийн индексүүд өсөлттэй хаагдлаа. STOXX Europe 600 индекс 0.61% өссөн бол DAX индекс 0.66% өсөлттэй харин FTSE MIB индекс 2.91% уналттай байсан байна.

Европын Төв Банкны ерөнхийлөгч Кристин Лагарде ОУВС-ийн хуралдааны үеэр евро бүсийн улс орнуудад коронавирусын хүнд нөхцөл байдлыг давж гарахад нь шаардлагатай бүхий л арга хэмжээг авч тусална гэдгээ дахин мэдэгджээ. ЕТБ-ны зүгээс хөрөнгийн худалдан авалтын хэмжээг нэмэгдүүлэхэд бэлэн байгаагаа илэрхийлж, энэхүү урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдлаас эдийн засгаа аварч үлдэхийн тулд боломжит бүх арга хэмжээг авна гэсэн байна. ОУВС евро бүсийн энэ жилийн эдийн засгийн өсөлтийг -7.5%, харин дараа жил 4.7% байна гэж таамаглаж байна. 4-р сарын сангийн зөвлөлөөс 2019-2020 оны хооронд Европын Холбооны засгийн газрын өр 800 тэрбум еврогоор өсч, нийт ДНБ-ий 97.4% тэнцүү хэмжээнд хүрнэ гэж таамагласан байна. Евро бүсийн улсуудаас Грек болон Италийн засгийн газрын өр хамгийн их хэмжээнд буюу ДНБ-ий 150% хүрэх магадлалтай байгаа юм. Мөн Франц, Испани болон Португалийн хувьд ДНБ-ий 100% их хэмжээтэй болохоор байна.

Япон: Япон улсын хөрөнгийн зах зээлийн индексүүд энэ долоо хоногт харьцангуй сэргэлттэй байлаа. Nikkei индекс 399 пункт буюу 2.0% өсөлт үзүүлж 19,897.26 болсон боловч өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 15.9% бага байгаа юм. TOPIX индексүүд бага зэрэг өсөлттэй байсан ч өнгөрсөн жилийн мөн үеийнхтэй харьцуулахад харьцангуй бага байна. Баасан гаргийн байдлаар 1 ам.доллар 108 иентэй тэнцүү байна.

БНХАУ: Энэ долоо хоногт БНХАУ-ын индексүүд тогтмол өсөлттэй, Shanghai Composite индекс 2.0%, CSI 300 large-cap stock индекс 2.3% өсөлттэй байсан байна.

4-р сарын 10-ны өдөр зарлагдсан банкны зээллэгийн тайлангас БНХАУ мөнгөний бодлого эрчимжсэн нь харагдаж байлаа. Шинээр олгосон зээлийн хэмжээ огцом өссөн нь хөл хорионоос болж эрэлт хэт буурсан байсантай холбоотой.

Эх сурвалж: Troweprice.com

Олон улсын индексүүд	Улс	Хаалт	Өөрчлөлт
MSE TOP 20	Монгол	16,715.26	-0.65% ▼
Dow Jones	АНУ	24,242.49	2.21% ▲
S&P 500	АНУ	2,874.56	3.04% ▲
Nasdaq	АНУ	8,650.14	6.09% ▲
S&P/TSX	Канад	14,359.88	1.36% ▲
FTSE 100	Их Британи	5,786.96	-0.95% ▼
S&P/ASX 200	Австрали	5,487.50	1.86% ▲
Nikkei 225	Япон	19,897.26	2.05% ▲
Hang Seng	Хонг Конг	24,380.00	0.33% ▲

Бонд	Валют	Купон	Үнэ
Mongol 2024 (Хуралдай)	USD	8.750%	101.00
Mongol 2023 (Гэрэгэ)	USD	5.625%	93.17
Mongol 2022 (Чингис)	USD	5.125%	92.77
Mongol 2021 (Мазаалай)	USD	10.875%	100.68
DBM' 23 (Самурай)	JPY	1.520%	102.09
DBM' 2023	USD	7.250%	87.81
TDBM' 2020	USD	9.375%	99.73
MGMTGE' 2022 (Өүлэн)	USD	9.750%	80.33

Зах зээлийн хүү	Хаалт	Өөрчлөлт
Libor 1M	0.673	-0.14 ▼
Libor 3M	1.109	-0.11 ▼
Libor 6M	1.103	-0.12 ▼
Libor 1YR	0.982	-0.07 ▼
US 2YR Bond	0.200	-0.02 ▼
US 3YR Bond	0.250	-0.04 ▼
US 5YR Bond	0.356	-0.05 ▼
US 10YR Bond	0.640	-0.09 ▼

Валютын ханш	2020.04.17	Өөрчлөлт
USD	2,783.67	0.06% ▲
CNY	393.38	-0.51% ▼
EUR	3,014.44	-0.99% ▼
RUB	37.60	-0.29% ▼
KRW	2.29	-0.43% ▼
JPY	25.82	0.58% ▲
CAD	1,974.79	-0.95% ▼

Түүхий эд	Хэмжих нэгж	Хаалт	Өөрчлөлт
Алт /спот/	USD/t oz.	1,682.82	-0.82% ▼
Мөнгө /спот/	USD/t oz.	15.18	-2.49% ▼
Зэс	USD/lb.	235.70	4.32% ▲
Нүүрс	USD/MT	58.33	-4.31% ▼
WTI газрын тос	USD/bbl.	18.27	-19.73% ▼
Brent газрын тос	USD/bbl.	28.08	-10.80% ▼

Макро эдийн засгийн үзүүлэлтүүд	Хугацаа	Хэмжээ
Инфляцийн түвшин	2020. II	6.4%
Бодлогын хүү	2020. II	11.00%
Банк хоорондын зах зээлийн хүү	2020. II	10.95 %
Хадгаламжийн дундаж хүү /төгрөг/	2020. II	11.33%
Хадгаламжийн дундаж хүү /валют/	2020. II	4.71%
Зээлийн дундаж хүү /төгрөг/	2020. II	17.01%
Зээлийн дундаж хүү /валют/	2020. II	10.35%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо, Монголбанк, Bloomberg

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖИЙН АРИЛЖАА


Энэ 7 хоногт Монголын хөрөнгийн биржийн хоёрдогч зах зээлийн энгийн арилжаагаар нийт 43 компанийн 286.9 сая төгрөгийн 1,853,355 ширхэг хувьцаа арилжаалагдав.

“Монгол дизель” /MDZ/ компанийн хувьцаа 15.00%-аар буюу хамгийн ихээр өсөж 472.22 төгрөг хүрч хаагдсан бол “Увс чацаргана” /CHR/ компанийн хувьцаа 15.00%-аар буурч 255.00 төгрөгт хүрч хаагдлаа.

Мөн тайлант долоо хоногт ЗГҮЦ-ны анхдагч болон хоёрдогч зах зээл дээр арилжаа хийгдээгүй.


04-р сарын 17-ны өдрийн байдлаар зах зээлийн үнэлгээ 2,452.8 тэрбум төгрөгт хүрсэн бол MSE TOP-20 Индекс 16,715.26 нэгж болж, өмнөх 7 хоногийн үзүүлэлтээс 0.65%-аар буурсан байна.

MSE Индекс



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Арилжааны үнийн дүн /7 хоногоор, 2020 он/



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж

Засгийн газрын үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа

№	ҮНЭТ ЦААСНЫ НЭР	Арилжигдсан ширхэг	Үнийн дүн /төг/	Доод /төг/	Дээд /төг/	7 хоног	Хүү
-	-	-	-	-	-	-	-

Зах зээлийн тойм	Дүн (сая.төг)	
Арилжигдсан үнийн дүн	387.1	
Зах зээлийн үнэлгээ	2,452,757.9	

Зах зээлийн индексүүд	Хаалт	Өөрчлөлт
MSE Top 20	16,715.26	-0.65% ▼
MSE I индекс	7,852.70	0.46% ▲
MSE II индекс	7,503.00	-1.58% ▼

Идэвхтэй арилжагдсан хувьцаа	Ширхэг	Үнийн дүн
Дорнод авто зам	38,809	100,127,220
Фронттиер лэнд групп	180,000	54,000,000
Ард даатгал	50,258	35,641,268
Ард санхүүгийн нэгдэл	23,351	35,151,708
Ард кредит ббсб	450,162	33,303,021

Өсөлттэй хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Монгол дизель	472.22	15.00% ▲
Ремикон	27.90	14.63% ▲
Говь	200.38	8.26% ▲
Баянгол зочид буудал	27,000.00	8.00% ▲
Эрдэнэ ресурс девелопмент корп	500.00	4.17% ▲

Бууралттай хувьцаа	Хаалт	Өөрчлөлт
Увс чацаргана	255.00	-15.00% ▼
Сор	850.00	-15.00% ▼
Агротехимпекс	770.00	-14.44% ▼
Багануур	850.00	-14.40% ▼
Фронттиер лэнд групп	300.00	-11.76% ▼

Арилжаанд идэвхтэй оролцсон ҮЦК	Дүн (төг)
БиДиСек	271,534,252
Ард Секюритиз	205,768,669
Евразиа капитал монголиа	108,000,000
Голомт Капитал	34,335,422
Бумбат-Алтай	27,273,96

Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 5 компани	Хаалт (төг)	ЗЗҮ (сая.төг)
АПУ	533.00	567,209
Таван толгой	5,340.00	281,232
МИК Холдинг	11,910.00	246,648
Инвексор ББСБ	2,490.00	178,603
Говь	200.38	156,319

НОГДОЛ АШИГ ЗАРЛАСАН ХУВЬЦААТ КОМПАНИУД

№	СИМБОЛ	КОМПАНИЙН НЭР	2019 ОНЫ ЦЭВЭР АШИГ /САЯ ТӨГ/	НИЙТХУВААРИЛАХ НОГДОЛ АШИГ /САЯ ТӨГ/	НОГДОЛ АШИГ ТӨЛӨЛТИЙН ХАРЬЦАА	НЭГЖ ХУВЬЦААНЫ НОГДОЛ АШИГ /ТӨГ/	БҮРТГЭЛИЙН ӨДӨР	ХУВААРИЛАХ ӨДӨР
1	APU	АПУ	74,411.5	75,471.2	101.4%	71.0	2020.02.14	2020.08.31-НИЙ ДОТОР
2	MNDL	МАНДАЛ ДААТГАЛ	5,820.3	2,497.2	42.9%	4.0	2020.04.01	2020.06.30-НЫ ДОТОР
3	GTL	ГУТАЛ	2,403.7	2,436.0	101.3%	1,520.0	2020.03.13	2020.05.05-НЫ ӨДӨР
4	LEND	ЛЭНДМН	4,910.2	1,200.0	24.4%	1.5	2020.02.25	2020.04.30-НЫ ӨДӨР
5	ADB	АРД КРЕДИТ ББСБ	2,369.4	1,184.7	50.0%	4.2	2020.04.08	2020.04.30-НЫ ДОТОР
6	AARD	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	715.9	1,000.0	139.7%	35.0	2020.04.07	2020.04.30-НЫ ДОТОР
7	TUM	ТҮМЭН ШУВУУТ	3,232.9	960.0	29.7%	4.8	2020.04.07	2020.06.24-НЫ ӨДӨР
8	AIC	АРД ДААТГАЛ	1,718.7	850.0	49.5%	34.0	2020.04.09	2020.06.30-НЫ ДОТОР
9	JTB	ЖЕНКО ТУР БЮРО	1,253.8	799.9	63.8%	10.0	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
10	TEX	ТЕХНИК ИМПОРТ	2,718.2	723.4	26.6%	500.0	2020.03.01	2020.04.24-ӨӨС
11	BUK	УЛААНБААТАР БУК	2,465.3	526.2	21.3%	4.0	2020.03.30	2020.06.01-ЭЭС
12	MMX	МАХИМПЕКС	819.3	456.1	55.7%	120.0	2020.04.03	2020.10.01-ЭЭС
13	MFC	МОНОС ХУНС	761.9	408.9	53.7%	1.0	2020.03.11	2020.08.31-НИЙ ДОТОР
14	DSS	ДАРХАН СЭЛЭНГИЙН ЦТС	581.8	391.8	67.3%	37.7	2020.03.20	2020.09.02-НЫ ӨДӨР
15	MNP	МОНГОЛ ШУУДАН	1,103.6	331.1	30.0%	3.3	2020.04.05	2020.05.01-ЭЭС
16	HRM	ГЕРМЕС ЦЕНТР	820.0	322.0	39.3%	4.1	2020.02.28	2020.03.15-ААС
17	NEH	ДАРХАН НЭХИЙ	2,327.6	230.8	9.9%	210.0	2020.02.25	2020.09.30-ААС
18	TCK	ТАЛХ ЧИХЭР	2,456.0	230.3	9.4%	225.0	2020.02.18	2020.06.20-ООС
19	MBW	МОНГОЛ БАЗАЛЫТ	335.0	225.7	67.4%	4.0	2020.03.09	2020.06.30-НЫ ДОТОР
20	BNG	БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ	2,117.8	152.3	7.2%	360.0	2020.04.05	2020.09.01-НИЙ ӨДӨР
21	BDS	БИДИСЕК	19.9	136.9	687.0%	10.0	2020.03.09	2020.12.31-НЫ ДОТОР
22	EER	АРИГ ГАЛ	225.8	131.0	58.0%	38.9	2020.03.27	2020.06.30-НЫ ДОТОР
23	TAN	ТАХЬКО	489.0	128.5	26.3%	108.0	2020.04.10	2020.05.01-НИЙ ДОТОР
24	UBH	УЛААНБААТАР ХИВС	298.8	121.4	40.6%	300.0	2020.03.06	2020.05.01-ААС 2020.05.15-НЫ ХООРОНД
25	HRD	ХҮРД	722.6	72.4	10.0%	535.0	2020.03.02	2020.06.30-НЫ ДОТОР
26	ATR	АТАР ӨРГӨӨ	280.4	60.9	21.7%	350.0	2020.04.01	2020.08.01-НЫ ДОТОР
27	MCH	МОНГОЛЫН ЦАХИЛГААН ХОЛБОО	62.0	25.9	41.7%	1.0	2020.04.06	2020.06.01-ЭЭС
28	HUV	ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ	324.7	21.6	6.7%	150.0	2020.04.03	2020.05.01-ЭЭС
29	SUU	СҮҮ	5,668.0	1,715.1	30.3%	5.0	2020.03.27	2020.05.01-ЭЭС
30	HZB	ГАН ХЭРЛЭН	31.9	15.0	46.9%	150	2020.04.06	2020.09.30-НЫ ДОТОР
31	BTG	БАЯНТЭЭГ	2,166.2	500.0	23.1%	1,979.3	2020.02.07	2020.12.01-НИЙ ДОТОР

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ



УИХ-ын Эдийн Засгийн Байнгын Хорооны 2020 оны 4-р сарын 15-ны өдрийн хуралдаанаар Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцлээ.

Хуралдаанд Санхүүгийн зохицуулах хорооны дарга Д.Баярсайхан хөрөнгийн зах зээл, даатгалын зах зээл, бичил санхүүгийн зах зээлийн 2019 оны гол үзүүлэлтүүд, тэдгээрийн өөрчлөлт, зохицуулалт, хяналтын чиглэлээр хийгдсэн арга хэмжээ, тулгамдаж буй асуудлын талаар танилцуулав. Мөн 2020 онд хэрэгжүүлж эхлээд буй томоохон арга хэмжээнүүд болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй гол ажлуудынхаа талаар мэдээллээ.

Эх сурвалж: Санхүүгийн Зохицуулах Хороо

ХУВЬЦААТ КОМПАНИУДЫН МЭДЭЭЛЭЛ

Дараах хувьцаат компаниудын хувьцаа эзэмшигчдийн хурал цахим хэлбэрээр зохион байгуулагдана

Covid-19-ийн халдварын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор 04-р сарын 17-ны байдлаар дараах хувьцаат компаниуд хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахимаар хийхээр шийдвэрлэсэн байна Үүнд:

1. "АСБИ" ХК 2020 оны 4-р сарын 24-ний өдрийн 10:00 цаг
2. "Монгол Шуудан" ХК 2020 оны 4-р сарын 22-ны өдрийн 10:00 цаг
3. "Тахько" ХК 2020 оны 4-р сарын 30-ны өдрийн 10:00 цаг

Эх сурвалж: Монголын Хөрөнгийн Бирж

"Сүү" ХК хувьцаа эзэмшигчид нэмж хувьцаа гаргах асуудлыг дэмжлээ

МХБ-ийн үнэт цаасны I ангилалд бүртгэлтэй "Сүү" /MSE:SUU/ ХК-ийн хувьцаа эзэмшигчид өнөөдөр 2020 оны ээлжит хурлаа цахим хэлбэрээр хийж, хэд хэдэн онцлох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв. Үүний нэг нь хөрөнгө оруулагчид, хувьцаа эзэмшигчдийн анхааралд байсан нэмж хувьцаа гаргах төсөл байсан бөгөөд хувьцаа эзэмшигчдийн дийлэнх олонх нь уг асуудлыг дэмжсэн байна.

Ийнхүү "Сүү" ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 25% хүртэлх хэмжээний буюу нийт 85,589,000 ширхэг энгийн хувьцаа гаргахаар боллоо. Харин нэмж гаргах хувьцааны андеррайтераар "Нэйшнл сэкюритис" ҮЦК ажиллаж байгаа ба одоо эрх бүхий байгууллагууд болох Монголын Хөрөнгийн Бирж болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос хувьцаагаа олон нийтэд санал болгох зөвшөөрөл авах юм.

Эх сурвалж: MarketInfo.mn

"Гермес центр" ХК сүүлийн хагас жилийн ногдол ашгаа олгов

"Гермес центр" /MSE:HRM/ ХК 2019 оны цэвэр ашгаас олгож буй ногдол ашгаа хувьцаа эзэмшигчдийнхээ дансанд байршуулсан талаар ҮЦТХТ-өөс мэдээллээ.

Компани жилдээ 2 удаа ногдол ашиг олгодог бөгөөд энэ удаагийн олголт нь 2019 оны сүүлийн хагас жилийн цэвэр ашгаас олгож буй мөнгө юм.

Тодруулбал, 2020.04.16-ны өдөр 950 хувьцаа эзэмшигчийн нэгж хувьцаанд 3.69 төгрөг буюу нийт 41.2 сая төгрөгийг байршуулжээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

"Дорнод авто зам" ХК-ийн 51.8% багцын арилжаагаар зарагдав

"Дорнод авто зам" /MSE:DAZ/ ХК-ийн 38,809 ширхэг хувьцаа нэг бүр нь 2,580 төгрөгийн ханш дээр 100.1 сая төгрөгөөр зарагдлаа. Энэ нь компанийн нийт гаргасан хувьцааны 51.8% нь болж байна.

"Дорнод авто зам" /MSE:DAZ/ ХК нь МХБ-ийн хувьцааны III ангилалд бүртгэлтэй, Дорнод аймагт зам засвар, арчилгааны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа.

2019 онд 664.1 сая төгрөгийн орлого олж, 6.1 сая төгрөгийн буюу нэгж хувьцаандаа 81.59 төгрөгийн ашигтай ажиллажээ.

Эх сурвалж: MarketInfo.mn

ЗАХ ЗЭЭЛИЙН БУСАД МЭДЭЭ

ОНЦЛОХ МЭДЭЭ

Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 4-р сарын 13-ны өдрийн ээлжит бус хурлаар бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж 9 хувьд хүргэх, эргэн төлөлт нь хүндрэлд орсон зээлдэгчийн хэрэглээний зээлийн хугацааг 12 хүртэлх сараар сунгах шийдвэр гаргалаа.

Мөнгөний бодлогын хорооны энэ удаагийн шийдвэр нь инфляцийн зорилтыг алдагдуулахгүйгээр эдийн засгийн болон санхүүгийн тогтвортой байдлыг хадгалахад дэмжлэг болно.

Эх сурвалж: BloombergTV.mn



МАКРО ЭДИЙН ЗАСАГ

2020 онд ипотекийн зээлийн санхүүжилтэд төсөвт батлагдсан эх үүсвэртэй нийлээд 300 орчим тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгох боломжтой гэсэн тооцоог Монголбанк гаргаад байна.

Ипотекийн зээлийн үлдэгдлийг харвал Монголбанк, Засгийн газраас хэрэгжүүлж байгаа орон сууцны ипотекийн тогтвортой тогтолцоог бий болгох хөтөлбөрийн хүрээнд нийт 3.4 их наяд төгрөгийн зээлийг 72 орчим мянган зээлдэгч авчээ.

Цар тахлын улмаас өрхийн орлого буурч байгаатай холбоотойгоор дээрх 72 мянган зээлдэгчдэд ипотекийн зээл төлөлтийг зургаан сараар хойшлуулахаар боломж олгох шийдэлд хүрч, УИХ-аар батлагдах хүлээлттэй байна. Ингэснээр өрхийн орлогын чадамжийг дэмжих, мөн банкны зээлийн чанар муудах зэргээс сэргийлэх алхам болж байгаа гэж үзэж байгаа юм.

Эх сурвалж: BloombergTV.mn

ТҮҮХИЙ ЭДИЙН ЗАХ ЗЭЭЛ

Хонгконгийн Хөрөнгийн биржид бүртгэлтэй "Mongolian Mining Corporation"-ийн нүүрсний гарц жилийн өмнөхтэй харьцуулахад нэг хувиар нэмэгдэж, 1.8 сая тонн болсон байна. Хэдий тийм боловч энэ нь өмнөх улиралтай харьцуулахад 38 хувиар буурчээ.

Тус компани нүүрсний үйлдвэрлэлдээ түр хугацааны зохицуулалт хийх зэргээр урьдчилан тооцоолох боломжгүй нөхцөл байдалд зориулсан арга хэмжээнүүд авч хэрэгжүүлж байгаа талаар тайландаа дурджээ.

Эх сурвалж: BloombergTV.mn



МЭДЭГДЭЛ

Энэхүү хэвлэл /мэдээлэл, судалгаа/ нь "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК-ийн нэрийн өмнөөс зөвхөн өөрийн үйлчлүүлэгчид /харилцагчид/-д мэдээлэл хүргэх зорилгоор бэлтгэгдсэн ба энэ нь аливаа нэг хөрөнгө оруулалтын зөвлөгөө болон аливаа санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах санал биш болно. Судалгаа /хэвлэл/-г бэлтгэх үеийн байдлаар түүнд агуулагдаж буй мэдээллийн үнэн бодит байдлыг хангах талаар шаардлагатай ажиллагааг хийсэн бөгөөд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК нь мэдээллийн үнэн бодит байдалд баталгаа гаргахгүй. Энэхүү мэдэгдэлд агуулагдаж буй мэдээллийг үйл ажиллагаандаа шууд болон шууд бус байдлаар ашигласнаас үүдэн аливаа хувь хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд учирсан хохиролд "Ти Ди Би Капитал ҮЦК" ХХК хариуцлага хүлээхгүй болно.